

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол улс нь бага-дунд орлоготой, байгалийн баялгийн арвин их нөөцтэй, шилжилтийн шатанд яваа нээлттэй эдийн засаг бүхий улс юм. Өнгөрсөн 34 жилд Монгол улсын эдийн засаг хурдацтай өсөж, нийгэм, эдийн засгийн олон үзүүлэлтүүд сайжирчээ. Гэвч Монгол Улсын эдийн засгийг баялгийн оновчтой бус ашиглалт, төсвийн үр ашиггүй зарцуулалт, татвар болон зохицуулалтын таатай бус орчин зэрэг асуудлууд хойш татаж байна. Хувийн болон төрийн секторын өрийн хэмжээ ихсэж, эдийн засаг уул уурхай, олборлолтын дэд салбараас шууд хамааралтай болсон нь дэлхийн эдийн засгийн цочролд, түүний дотор хүүний өсөлт, ханшийн болон түүхий эд, эрдэс баялгийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий болжээ. Энэ нь эдийн засгийн тогтвортой өсөлтөөс илүүтэй уналт, сэргэлтийн мөчлөгтэй нүүр тулж байна. Уул уурхайн салбараас улсын төсөвт 2021 он 3.4 ихнайд төгрөгийн орлого олохоор тооцож байсан дүн, 2024 онд 8.0 ихнайд болсон нь уул уурхайгаас хараат болох бодлого төсвөөр дамжин хэрэгжиж байна гэж дүгнэхээс өөр аргагүй. Үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлж буй бодлогын хувьд хоорондын уялдаа холбоо сул, эдийн засаг, нийгмийн онцлогийг бүрэн тусгаагүй, хэрэгжилт муутай байдаг. Түүхий эдийн мөчлөгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулахад түлхэц болох бодлого бол үндэсний үйлдвэрлэлийг дэмжих явдал юм. Уул уурхайгаас өндөр хамаарал бүхий манай орны хувьд түүхий эдийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс урьдчилан сэргийлэхийн тулд хэрхэн эдийн засгийг төрөлжүүлэх, өндөр бүтээмжтэй салбарын дэд бүтцийг хөгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулах ёстой юм.

Эдийн засгийг солонгоруулахад төрийн оролцоо буюу татварын бодлогоор дэмжих ёстой байдаг. Өөрөөр хэлбэл, төр татаас болон санхүүгийн урамшуулал олгох, тодорхой үйл ажиллагаануудад квот болон тариф тогтоох замаар зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх ёстой.

Манай улсын эдийн засаг аж үйлдвэржилтийн үр дүнд ажил эрхлэлт, нэг хүнд ногдох орлого, хүн амын амьжиргааны түвшин бодитоор дээшлэх тул Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар үндэсний үйлдвэрлэлийг сэргээх үйл ажиллагаанд төр шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэж, хөрөнгө оруулалт татах эрх зүйн таатай орчин бий болно. Мөн гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдснээр ажлын байр шинээр нэмэгдэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улсын татварын хэмжээ эрс нэмэгдэх боломж бүрдэнэ.

Тус хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн сөрөг нөлөө гарахгүй бөгөөд тодорхой хугацааны дараа төсөвт орох орлого огцом нэмэгдэнэ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ